

Хүн ба байгалийн харилцан холбооны тухай Л. Фейербахын үзэл баримтлал

Г.Лодой- МУИС. НШУС.Философийн тэнхмийн багш, профессор

Түлхүүр үгс : хүн судлалын материализм, хүн ба байгалийн нэгдэл, хүний мөн чанар, байгалийн мөн чанар.

Орчлон ертөнц, түүний үүсэл гарвал, ертөнцөд хүний эзлэх байр суурь, хүн ба байгалийн харилцан холбооны асуудал философийн мөнхийн асуудлын нэг байсан бөгөөд экологийн хямрал дэлхий нийтийг хамарсан тулгамдсан асуудал болж буй эдүгээ үед байгаль, хүн, нийгмийн харилцан холбооны асуудал философийн төдийгүй шинжлэх ухааны бүх салбарт зайлшгүй харгалзан үзэх ёстой хүчин зүйлсийн нэг болоод байна. Байгаль бол хүний оршихуйн язгуур үндэс, хөдөлмөр үйл ажиллагааны зайлшгүй нөхцөл, эх үүсвэр нь төдийгүй хүний ухамсар, танин мэдэхүй, үйл ажиллагааны оногдохуун болж байдаг утгаараа хүний оршихуйн салшгүй хэсэг болж байдаг билээ. Ийм учраас хүн ба байгалийн харилцан холбооны тухай философийн янз бүрийн үзэл баримтлалыг шинжлэн судлаж, үнэлэн цэгнэх нь орчин үед чухал ач холбогдолтой хэвээр байгаа болно.

Хүн, байгалийн харилцан холбооны асуудлыг философийн үзэл баримтлалдаа тусгайлан судлах зорилт тавьж тал бүрээс нь судлан шинжлэх оролдлого хийсэн хүмүүсийн нэг бол Л.Фейербах юм.

Хүн, байгаль, танин мэдэхүйн холбогдол бүхий аливаа асуудлыг авч үзэхдээ Л.Фейербах теологийн болон философийн идеализмийн үзэл баримтлалыг шүүн шинжилж няцаахын сацуу механик материализмын сургаалыг өрөөсгөл хэмээн буруушааж байсан билээ. Философийн үзэл баримтлалаа боловсруулахдаа Л.Фейербах эн тэргүүнээ Гегелийн идеализмийн үндсэн зарчмыг шүүмжлэн няцааж, материализмыг шинэчлэн хөгжүүлэх зорилт тавьсан байдаг. Гегелийн философид байгалийн мөн чанарыг хүний сэтгэхүйд оршин байдаг ойлголтуудаар дамжуулан тайлбарлаж болох мэт үндэслэлийг дэвшүүлдэг бөгөөд байгаль бол сэтгэгдэхүүн болж буй мөн чанаруудын ертөнц гэж Гегель үзэж байв. Гегелийн үзлээр, хүн өөрөө хүн төрөлхтөний субстанцлаг оюун ухааны хүнийссэн бодгаль ахуй бөгөөд тэрхүү түгээмэл оюун ухаан хүн болон байгалиар дамжуулан өөрийгөө танин мэддэг ажээ. Энэ утгаараа өөрийгөө танин мэдсэн туйлын оюун санаа нь бүхнийг тайлбарлах эх үндэс, оршин буй бүхний шалгуур, хөгжил хувьслын чиглүүлэгч шалтгаан болох учир бүхнийг бүтээгч эхлэл гэсэн теологийн ойлголттой ижил утгатай болж ирдэг.

Идеализмийн гол баримтлал нь “байгалийн юмс гэдэг бол оюун ухаанд илэрхийлэгдэж буй зүйлс” гэдэг томъёололд үндэслэдэг. Энэ үндэслэлийг үнэн магадтай болгохын тулд логик зайлшгүй гэдэг зарчмыг идеализм хэрэглэдэг. Логикийн хувьд зайлшгүй бүхэн юмсын уг чанараас үүдэлтэй бөгөөд ийм учраас логик зайлшгүй бол мөнх, жинхэнэ бодитой, ямар нэгэн хүсэл зоригоос үл хамаарах шинжтэй гэж үздэг. Ийм учраас логикийн хувьд зайлшгүй бус юмс нь ямар нэгэн утга учиртай бус, төдийгүй оршин байх эрх төгөлдөр бус гэсэн үзэл санааг идеализм, тухайлбал, Гегель өөрийнхөө философийн сургаалд дэвшүүлж байв.

Фейербах философийн үзэл баримтлалдаа Гегелийн идеализмийг шүүмжилж, байгалийн уг чанарыг өөрөөс нь тайлбарлах ёстой гэсэн зарчмыг баримтлаж байв. Гэхдээ байгалийг хүнээс ангид орших ямар нэгэн тусгаар биет ертөнц гэж үзэхийг буруушааж механик материализмыг шүүмжилж байв. Жинхэнэ үнэн философийн баримтлал бол материализм байх ёстой хэдий боловч зөвхөн байгалийг баримжаа болгох ёсгүй, харин хүн байгаль хоёрыг нэгдэлд нь авч үзэж тайлбарлах ёстой гэсэн үзэл санааг гол баримтлалаа болгож байжээ. Түүний үзлээр, философийн шинэ үзэл баримтлал нь "хүн төвт материализм" байх ёстой ажээ. Тэр бээр бичихдээ: "Шинэ философиийн сургаал нь хүнийг түүний язгуур үндэс болох байгалийнх нь хамт философийн нийтлэг, эрхэм дээд, цорын ганц судлагдахуун болгож байгаа учир антропологи, мөн түүнчлэн физиологийг бүхнийг хамарсан шинжлэх ухаанд хувиргаж буй"¹ гэсэн нь хүн судлалын материализмыг ирээдүйн философийн гол чиглэл болгон тунхагласан хэрэг юм.

Цэвэр оюун ухааныг дээдэлсэн философийн онол сургаал нь хүний хувьд юу ч биш, бараг хэрэггүй зүйл бөгөөд "үнэн юм гэдэг бол эдүгээ орших, бодитой, мэдрэгдэхүйц, илт тодорхой, хүнд холбогдолтой байх ёстой. Зөвхөн хүнд холбогдолтой, мэдрэгдэхүйц, бодитой зүйл л үнэн байна"² гэж Фейербах онцлон тэмдэглэсэн байдаг нь санамсаргүй хэрэг биш билээ. Байгаль, ертөнцийг зөвхөн оногдохуй буюу объект болгон үзэх хандлага Фейербахаас өмнөх үеийн материализмд зонхилж байсныг тэр бээр зөв олж харж шүүмжилсэн боловч хүн байгалийн харилцаанд хүний идэвхтэй үйл ажиллагаа чухал үүрэгтэй болохыг онцлон анхаараагүй явдал түүний философийн нэгэн дутагдал байсан байж болох юм. Энэ талаар түүний дараах үеийн философид, тухайлбал Марксизмын философид шүүмжилж байсан баримтууд цөөнгүй байдаг.

Хүн төвт шинэ философийн үзэл баримтлалын гол онцлог нь "Фейербахын өгүүлсэнээр." Юмыг хийсвэр оюун ухааны оногдохуун болгож үзэх бус, харин бодит, цогц хүний оногдохуун болгон төсөөлдөгт оршино. Энэхүү философи нь нэргүй, тодорхойгүй хэлээр ярьдаг бус, хүний хэлээр ярьдаг бөгөөд тэр бээр аливаа санааг материас, мөн чанараас, мэдэрхүйгээс үүтгэлтэйгээр бүтээдэг"³ ажээ. Хийсвэр оюун ухааныг бүхний шалгуур болгодог рационализмын үзэл санааг шүүмжлэхдээ Фейербах "би сэтгэж байгаа учраас оршин байгаа нь үнэн" гэсэн Декартын томъёололын оронд "би мэдэрч байгаа учраас оршин байгаа болно" гэсэн сенсуалист баримтлалыг сэргүүлэн тавьж байв. Тэр бээр бичихдээ: "Сэрэхүй бол онтологийн, метафизикийн утга холбогдолтой: сэрэлд аугаа, гүн гүнзгий үнэнүүд агуулагдаж байдаг. Иймээс бидний тархи толгойноос гадна юм байна гэдгийн онтологийн жинхэнэ баталгаа нь сэрэл, таашаал болно."⁴/4/ гэжээ. Энэ өгүүлэмжийн гол утга нь бодит байдал, байгаль, ертөнцийг хүнтэй холбож байдаг гол шижим гүүр нь мэдэрхүй гэсэн санаа юм.

Хүн, байгаль хоёрыг нэгдэлд нь авч үзэж, байгаль руугаа буюу хүн өөрийнхөө язгуур уг чанартайгаа холбогдох нь философийг эрүүлжүүлэх эх

¹ Фейербах. Л. Избр. Философ. Произведение. т.1, с.202.

² Фейербах Л. История философии. Т.1, с. 39.

³ Фейербах Л. Избр. философ. Произведение. т. 2, с. 19.

⁴ Мөн тэнд. боть 2, 185 дахь тал.

сурвалж болно⁵ гэж Фейербах үзэж байжээ. "Миний сургаал буюу үзэл баримтлалыг **байгаль ба хүн** гэсэн хоёр үгээр илэрхийлж болох юм."⁶ Ингэснээр байгалийг хүмүүнлэг, ухамсрагдсан, оюун ухаанлаг болгож болно гэсэн итгэлийг тэрбээр өвөрлөж, хүн байгалийн нэгдмэл чанарыг философийн үүднээс үндэслэх зорилт дэвшүүлсэн нь тухайн үедээ шинэлэг бөгөөд зоримог алхам байлаа.

Фейербахын үзлээр, ахуйн мөн чанарт хүн холбогдолтой бөгөөд ахуйн зайлшгүй агшин нь хүн болж байдаг ажээ. Өөрөөр хэлбэл, хүнээс гадна орших ертөнцийн мөн чанарын зэрэгцээ түүнээс ялгаатай хүний мөн чанар гэж байх ёсгүй бөгөөд ахуй нь нэгдмэл нийтлэг мөн чанартай болохын амьд төлөөлөл нь байгалийн өөрийнх нь хөгжлийн дээд шат болох хүн байх ёстой учир байгалийн хувьсал хөдөлгөөний хүнээс өмнөх үеийн хэлбэрүүд нь хүний ахуйд нэгдэн нийлэгжих учиртай гэж үзээд, "байгаль бол хүний ахуйгаас салгаж үл болох мөн чанар болно"⁷ гэж тэрбээр бичсэн байдаг. Энэ санаа нь "организм бол механик, физик, химийг нэгэн бүхэл болгон нэгтгэсэн дээд нэгдэл учир энэхүү гурвалыг ахин салгаж болохгүй"⁸ гэсэн Ф.Энгельсийн дүгнэлттэй ойролцоо утгатай юм. Мөн иймэрхүү үзэл санааг Гегель "Логикийн ухаан" зохиолдоо томъёолсон байдаг.

Байгалийг оюун санааны ойлголтуудын биежсэн хэлбэр мэтээр тайлбарладаг идеалист баримтлалуудыг үгүйсгэж, байгаль бол өөрөө өөрийгөө бүтээж байдаг мөн чанартай гэсэн монист үзлийг Фейербах баримталж байжээ. "Байгаль бол чиний харж буй бүхэн бөгөөд хүний гар, сэтгэхүйгээр бүтээгдээгүй бүх зүйлс юм. Өөрөөр хэлбэл, байгалийн тогтолцоог шинжвээс, байгаль гэдэг бол оршин байхуйн үндэс нь санаа бодол, хүсэл зоригийн шийдвэртэй холбоогүй, харин механикийн, химийн, физикийн, физиологийн буюу органикийн болон сансрын хүчин шалтгаантай холбоотой биесийн цогц юм"⁹ гэсэн буй. Ийнхүү байгаль өөрийгөө бүтээгч нэгдмэл мөн чанартай учир хүн бол түүний нэгэн салшгүй хэсэг, биет, мэдэрхүйт амьтан болохын хувьд ахуй сэтгэхүйн нэгдлийг нөхцөлдүүлэгч гол цөм нь болох ёстой ажээ.

Хүний танин мэдэхүйн тэмүүлэл нь орчлон ертөнц болж байдаг тул бодит байдлын бүхий л харилцаа холбоо нь хүнд төвлөрч, хүнээр дамжин ухамсарлагдаж байдаг тул байгалийн мөн чанарыг танин мэдэх түлхүүр нь хүн болох учиртай гэсэн санаа Фейербахын материализмын гол тулгуур баримтлал нь байжээ.

Байгалиас хүний ялгагдах шинж нь хүн өөрийгөө ухамсарладаг, ухамсарт үйл ажиллагаа явуулдагт оршдог боловч энэхүү ухамсарт үйл ажиллагаа нь байгалиас үүдэлтэй үйл явц байдаг гэж тэрбээр үзэж байв. Байгалийн объектив мөн чанарыг хүний субъектив мөн чанартай холбон үзэхийн сацуу хүний мөн чанарыг байгалийн өөрийнх нь мөн чанарын илрэл гэж үзэх нь " нэгдмэл

⁵ Мөн тэнд. аоть 1, 96 дахь тал.

⁶ Мөн тэнд. боть 2, 515 дахь тал.

⁷ Мөн тэнд. боть 1, 129 дахь тал.

⁸ Маркс .К, Энгельс. Ф, Соч., т. 20. с. 366.

⁹ Фейербах.Л. Избр. философ. произведение. т. 2. с. 591.

чанарыг олон янз байдалд нь, олон янз байдлыг нэгдэлд нь ойлгоно” гэсэн диалектик санаа болохыг анзаарч болно. Энэхүү диалектик холбоог үл ойшоох аваас аль нэг талыг нь туйлчилж, улмаар идеализм болон шашны номлолд хүргэж болохыг Фейербах онцлон анхааруулж байжээ. Хүний ухамсар, оюун санааны субъектив талыг туйлчилж, биеэ даасан бүтээгч хүчин мэт болгох аваас шашин, идеализмд хүргэдэг бол байгалийг хүнээс салгаж, идэвхигүй амьд бус ертөнц болгох нь механик материализмын үндсэн дутагдал байсныг Фейербах зөв зүйтэй олж харсан байдаг. Байгалийн мөн чанар, түүний өөрийнх нь түүх хүний ахуйн мөн чанараар дамжин танигдаж, ухамсрагдаж байдаг гэсэн санаа эдүгээ ач холбогдлоо алдаагүй байгааг анхаарууштай. Орчин үеийн экологийн хямралт нөхцөл байдлын учир шалтгааныг байгаль орчныг техникийн хүчин зүйлсийг ашиглан явцуу утилитар эрх ашгийн үүднээс өөрчилсөнтөй холбон тайлбарлахын оронд түүний нийгэм –түүхийн уг чанарыг нь бүрхэгдүүлэхийг хичээж, философийн түүхийн өв сангаас түүнийг зөвтгөх үзэл санааг эрэлхийлж байгаа оролдлогод няцаалт өгөхөд Фейербахын үзэл санаа зохих ач холбогдолтой юм.

Фейербахын үзлээр, хүний ахуйн мөн чанар нь байгалийн ахуйн үндэс суурь болдог бус, харин байгалийн оршин тогтонохуйн механизмыг онолын үүднээс ухаарах үндэс, хүн байгалийн харилцан холбоог зөв ойлгох эхлэл нь хүний тухай асуудал байх ёстой ажээ. Энэ тухай тэр бээр өгүүлэхдээ: “Би байгалийн үүсэл гарвал, үйл явцыг тайлбарлахыг хүсвэл хүний мөн чанарыг эхлэл үндэслэлээ болгох ёстой”¹⁰ гэжээ. Үүний гол утга санаа нь байгалийн болон хүн төрөлхтний түүхүүд харилцан бие биенээ нөхцөлдүүлж байдаг бөгөөд байгалийг тайлбарлах түлхүүр нь хүн судлалд оршино гэсэн үг юм.

Хүн ба байгалийн харилцан үйлчлэлийн явцад хүн байгалийг, өөрийгөө, хүмүүс хоорондын харилцаагаа танин мэддэг бөгөөд хүн байгалийн харилцаа нь практик асуудал болохыг тэмдэглэж, “ахуйн тухай асуудал бол практик амьдралын холбогдолтой юм” гэж Фейербах бичсэн байдаг. Хүнийг байгальтай нэгтгэж буй гол субъект нь бодит хүн байгаа цагт л хүн ба байгаль, сэтгэхүй хийгээд ахуйн жинхэнэ нэгдлийг сэтгэж, ойлгож болох ажээ. Хүнээс байгальтай харьцах харилцаа нь хүмүүсийн хоорондын харилцаагаар нөхцөлдсөн байдаг гэсэн санааг Фейербах дэвшүүлсэн боловч хүмүүсийн хоорондын харилцаа нийгэм-түүхийн хүчин зүйлсээр нөхцөлдсөн түүхэн цаг үеийнхээ нөхцөл байдалтай салшгүй холбоотой байдгийг нарийвчлан шинжлээгүйд түүний үзэл баримтлалын нэгэн дутагдал оршдог.

Хүн байгалийг эзэмших тухай асуудлыг Фейербах дэвшүүлэн тавьсан боловч ихэвчлэн энэ асуудлын талаарх идеалист тайлбарлалуудыг шүүмжлэхэд гол анхаарлаа хандуулж байжээ. Фейербахын үзлээр, философийн гол үүрэг бол амьдралын эрэлт хэрэгцээ, хүн төрөлхтний практик ашиг сонирхолд үйлчлэх явдал байх ёстой ажээ. Гэтэл философийн онол, сургаалууд энэхүү шаардлагыг хангаагүй бөгөөд “амьдралын алхам бүрдээ бид философийн гадна орхигдож, философийн сургаал бүхэнд амьдралаас гадуур тайлбарлагдаж” ирсэн учир философийн үүрэг зорилго нь “судар ном бүтээхэд бус, харин хүнийг бүтээхэд орших ёстой” гэж тэр бээр үзэж байсан нь сонирхолтой санаа юм.

Философийг хүн төрөлхтний практик зорилттой холбох гэсэн зөв санааг Фейербах дэвшүүлсэн хэдий боловч байгаль нийгмийн харилцааны үндэс нь зөвхөн хүний мөн чанартай холбоотой бус, нийт хүн төрөлхтний оюуны болон практик үйл ажиллагааны чиг хандлага, үр дүнгээс ихээхэн хамааралтай

¹⁰ Мөн тэнд . боть 1 . 266 дахь тал.

болохыг бүрэн гүйцэд ухаараагүйд түүний философийн бас нэгэн дутагдал оршдог.

Хүн байгаль хоёрыг нэгтгэж байдаг гол шижим нь нийгэм байдаг бөгөөд нийгмээс гадуур хүн байгалийн нэгдлийн асуудлыг авч үзэх нь хийсвэр төдийгүй хүний нийгэм-түүхийн мөн чанарыг ойлгоход бэрхшээл учруулдаг учир дутагдалтай болохыг олон судлаачид тэмдэглэсэн байдаг. Фейербахын материализмын ололттой тал нь ертөнцийг тайлбарлахад хүн байгаль хоёрын нэгдлийн зарчмыг үндэс болгохыг удирдлага болгож, хүний мөн чанарын тухай идеалист тайлбарлалд зөв зүйтэй няцаалт өгсөнд оршдог.

Ашигласан ном зохиол

- Фейербах .Л. История философии. т, 1,
- Фейербах. Л. Избр. философ. Произведение. т. 1,
- Маркс .К, Энгельс. Ф, Соч., т. 20
- Фейербах.Л. Избр. философ. произведение. т. 2